"МОНГОЛЫН ХАНГЛАЙДИНГ ПАРАГЛАЙДИНГИЙН НИЙГЭМЛЭГ" ГҮТББ

БАТЛАВ:

ЕРӨНХИЙЛӨГЧ ..... М.ЭНХБОЛД

2025 оны 08 дугаар сарын 08 өдөр

ПАРАГЛАЙДИНГИЙН ТАНДЕМ НИСГЭГЧИЙН ҮНЭМЛЭХ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар Монголын Ханглайдинг Параглайдингийн Нийгэмлэг /цаашид МХПН гэх/-с Монгол Улсад Параглайдераар тандем нислэгийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл болон тандем нисгэгчийн үнэмлэх олгох, сунгах, хүчингүй болгох, нислэгийн хэрэглэл, аюулгүй ажиллагааны шаардлага тодорхойлохтой холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Монгол Улсад Параглайдераар тандем нислэгийн үйл ажиллагаа явуулж буй гишүүн клуб болон хувь гишүүн нь энэхүү журмаар тавигдах шаардлагыг ханган биелүүлсний үндсэн дээр тандем нисгэгчийн үнэмлэх авч болно.

1.3. Монгол улсад тандем нислэг үйлдэх нисгэгч бүрд тандем нисгэгчийн үнэмлэх авсан байх шаардлага тавигдана. Энэхүү шаардлага нь Монгол улсын иргэний нисэхийн дүрэм 106, 115, 61 мөн агаарын орон зай, чөлөөт нислэгийг зохицуулдаг бусад дүрэм, журмуудтай нийцсэн болохыг МХПН батална.

1.4. МХПН- нь Параглайдингийн тандем нисэгчийн үнэмлэхийг Монгол улсын иргэнд олгоно.

ХОЁР. ТАНДЕМ НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗӨВШӨӨРӨЛ, НИСГЭГЧИЙН ҮНЭМЛЭХ

2.1 МХПН нь Тандем нисгэгчийг бэлтгэх сургалтын агуулгыг тодорхойлох, сургалтын үйл ажиллагааг гардан явуулах эрх бүхий сургагч багш, инструкторыг тодорхойлох, үйл явцыг хянах үүрэг хүлээнэ. Өөрөөр хэлвэл, тандем нисгэгчийн ур чадвар, туршлагын талаар ямар нэгэн баталгаа өгөхгүй. Гэхдээ эдгээр ур чадвар, туршлагыг батлах үнэлгээг тандем нислэгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл болон тандем нисгэгчийн үнэмлэх анх мэдүүлэх, эсвэл сунгах үед шаардах эрхтэй.

2.2 МХПН-с томилогдсон инструктор нь тандем нисгэгч бэлтгэх сургалтын агуулга, нислэг үйлдэхтэй холбоотой тавигдах шаардлага, аюулгүйн зааварчилгааг дагаж мөрдөх бөгөөд энэхүү журмын дагуу тандем нисэгчийн сургалтыг зохион байгуулж, холбогдох

шаардлага, шалгалтыг үндэслэн суралцагчдад инструкторуудын зөвлөлийн зөвшөөрлийн дагуу тандем нисгэгчийн үнэмлэх олгоно.

2.3 МХПН-с тандем нисгэгчийн үнэмлэхийг 2-р жилийн хугацаатай олгох бөгөөд үнэмлэх эзэмшигч нь тухайн жилд тус журамд заасан нислэгийг үйлдэж, нислэгийн бүртгэлээр баталгаажуулсны үндсэн дээр үнэмлэх хүчинтэй байна.

ГУРАВ. ТАНДЕМ НИСГЭГЧИЙН ЗЭРЭГЛЭЛ

3.1 Тандем нисгэгчийн үнэмлэхийн зэрэглэл нь Тандем 1 (T1) ба Тандем 2 (T2) гэсэн хоёр зэрэглэл байна.

3.2 **Тандем 1 (T1) үнэмлэх авахад тавигдах шаардлага:**

3.2.1 Үндэсний нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь 21 нас хүрсэн
3.2.2 T1 сургалтанд хамрагдахаас өмнө нэг жилийн турш P3 түвшний үнэмлэх эзэмшсэн
3.2.3 SIV сургалтад суусан байх /B далавч/
3.2.4 Бүртгэгдсэн бие даасан нислэгийн хугацаа хамгийн багадаа 200+ цаг, сүүлийн 12-р сарын хугацаанд 50+ цаг бие даасан нислэг хийсэн
3.2.5 T1 семинарыг амжилттай дүүргэж, практик шалгалтанд тэнцэх
3.2.6 Инструкторын удирдлаган дор 10 удаагийн тандем нислэг хийсэн
3.2.7 Инструкторын удирдлага, зөвлөмжийн дагуу P1-P5 шатны нисгэгчтэй хамт нэмэлт 20-н удаагийн тандем нислэг хийсэн
3.2.8 Инструкторын зөвлөлийн бичгийн болон аман үнэлгээнд тэнцсэн
3.2.9 ИНЕГ-н нисэгчийн эрүүл мэндийн шаардлагаар үзлэгт орж баталгаажсан
3.2.10 Анхны тусламж үзүүлэх сургалтад хамрагдсан гэрчилгээтэй байх
3.2.11 ИНД болон бусад холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтын талаарх мэдлэгтэй байх

3.3 **Тандем 1 (T1) үнэмлэх хадгалахын тулд нисгэгч дараахь зүйлийг хийх ёстой**

Үүнд:

3.3.1 Жилд дор хаяж ганцаарчилсан 50 нислэг хийж, бүртгэлээ баталгаажуулах
3.3.2 Жилд дор хаяж 10 тандем нислэг хийж, бүртгэлээ баталгаажуулах
3.3.3 Зөвшөөрөгдсөн стандартын тандем далавч, нөөц шүхэр, аюулгүйн хэрэглэл ашиглах
3.3.4 Тандем нислэгийн үеэр зөрчил, аваар осол гаргахгүй байх
3.3.5 Нислэгийн өмнөх тандемийн аюулгүй байдлын протоколыг дагаж мөрдөх
3.3.6 Хэрэв нисгэгч 1 жилээс дээш хугацаагаар тандем нислэг хийгээгүй бол T1 курст дахин Хамрагдаж, Инструкторын удирдлага доор 10-н удаагийн тандем нислэг хийх ёстой

3.4 **Тандем 2 (T2) үнэмлэх авахад тавигдах шаардлага:**

Тандем T2 нисгэгчийн үнэмлэх авахын тулд дараах шаардлагыг хангах ёстой Үүнд:

3.4.1 Параглайдерын инструктор, эсвэл P5 - Мастер нисгэгчийн үнэмлэхтэй байх
3.4.2 T1 лиценз авсанаас хойш 3-аас доошгүй жил ниссэн

3.4.3 250 цаг ганцаарчилсан нислэг үйлдсэн, нислэгийн цагийн дэвтрээр баталгаажсан /100 цаг нь термалл нислэг хийсэн, Варио төхөөрөмжөөр баталгаажуулсан байх/

3.5 **Тандем 2 (Т2) үнэмлэх хадгалахын тулд нисгэгч дараахь зүйлийг хийх ёстой. Үүнд:**

3.5.1 Багшийн гэрчилгээгээ хадгалах
3.5.2 Жилд дор хаяж 50 нислэг, түүний дотор 10 тандем хийх
3.5.3 Мэргэшсэн тандем далавч, зохих жингийн нөөц шүхэр, дагалдах хэрэгсэл ашиглах
3.5.4 Жил тутам дор хаяж нэг Тандем Т1-ийн семинарыг удирдаж явуулах
3.5.5 Багшийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх
3.5.6 Нислэгийн өмнөх тандемийн аюулгүй байдлын протоколыг дагаж мөрдөх

ДӨРӨВ. ТАНДЕМ НИСГЭГЧИЙН СУРГАЛТ

4.1 **Сургалтад тавигдах шаардлага:**

МХПН-с томилогдсон инструктор, сургагч багшийн удирдлага доор дараах сэдвийн хүрээнд тандем нисгэгчийн сургалтад хамрагдана. Сургалтын агуулга:

4.1.1 **Тандем далавчтай харьцах, гүйцэтгэлийн ялгаа**
Газарт болон нислэгийн үед далавчтай харьцах, тандем далавчны гүйцэтгэлийн ялгаа

4.1.2 **Хөөрөлт болон буух техник, жингийн зохицуулалт**
Хөөрөлт болон буултын үеийн үндсэн техник, нисгэгч болон зорчигчийн жингийн зохицуулалт хийх

4.1.3 **Нислэгийн өмнөх зааварчилгаа**
Зорчигчдод нислэгийн үеэр хэрхэн биеэ авч явах, аюулгүй байдлын хэрэгслийг хэрхэн ашиглах, ослын үед хэрхэн ажиллах талаар мэдээлэл агуулсан аюулгүй байдлын зааварчилгааны тухай

4.1.4 **Тандем хийх цаг агаарын нөхцөл**
Цаг агаарын үнэлгээ хийх. Салхины хурд, чиглэл, үүлний суурь, дулааны идэвхжил зэрэг нь тандем нислэгийн аюулгүй стандартыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулах.

4.1.5 **Далавч, суудал, техник хэрэглэлийн шалгалт**
Аюулгүй байдлын бүх хэрэгсэл, түүний дотор далавч, хамгаалалтын дуулга, өвдгөвч, суудал, аврах шүхрийг нислэгийн өмнө шалгаж, зохих ёсоор суурилуулах.

4.1.6 **Жин ба насны хязгаарлалт**
Зорчигчид тогтоосон жин, нас, эрүүл мэндийн шаардлага, сэтгэл зүйн байдлыг ажиглах, эрүүл мэндийн нөхцөл үүссэн тохиолдолд нислэгийг зогсоох, анхны тусламж үзүүлэх

4.1.7 **Тохиромжтой хувцас**
Зорчигчид тав тухтай, цаг агаарт тохирсон хувцас, бат бөх гутал өмсөх

4.1.8 **Аюулгүй ажиллагааны протокол**
Хөөрөх, нисэх, буух үед аюулгүй байдлын протоколуудыг чанд мөрдөх

4.1.9 **Архи, мансууруулах бодис**
Нислэгийн өмнө зорчигчид согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн эсэх, нислэгээс татгалзах тухай

4.1.10 **Хүндэтгэл ба харилцаа холбоо**
Зорчигчтой нислэгийн өмнө, нислэгийн үеэр харилцах

4.1.11 **Хариуцлагаас чөлөөлөгдөх тухай**
Тандем нислэгтэй холбоотой эрсдэлийг хүлээн зөвшөөрүүлэх, хариуцлагаас чөлөөлөх тухай гарын үсэг зуруулах

4.1.12 **Онцгой байдлын журам**
Нислэгийн үед далавч, суудал, нисгэгч, зорчигчийн нислэгийн аюулгүйн хэрэглэл гэмтсэн, эвдэрсэн, эсвэл цаг агаарын гэнэтийн өөрчлөлт гарсан тохиолдолд хэрхэн аюулгүй газардах тухай зэрэг онцгой байдлын арга барилыг эзэмшүүлэх.

4.2 **Шалгалт:**

4.2.1 **Онолын шалгалт**
Онолын хүрээнд үзсэн сэдвүүд, аэродинамик, цаг уур, аюулгүй байдал, ИНД, МХПН-ны журам, зааварчилгааны хүрээнд

4.2.2 **Практик тест** /нислэг/

- Нислэгийн өмнөх бэлтгэл, аюулгүйн ажиллагаа
- Зорчигчтой хамт хөөрөх, буух
- Янз бүрийн нөхцөлд нислэг үйлдэх
- Яаралтай байдлын менежмент (загварчилсан)

ТАВ: ТАНДЕМ НИСГЭГЧИЙН ҮНЭМЛЭХ ОЛГОХ, ЦУЦЛАХ

5.1 Тандем 1 болон Тандем 2-ын үнэмлэхийн сургалтад хамрагдаж, шалгалтаа баталгаажуулсан нисгэгч нь сургалт орсон инструктор, сургагч багшаар дамжуулан МХПН-д шаардлагатай баримт бичгийг хавсарган албан хүсэлт гаргана.

5.1.1 Үнэмлэх олгох комисс нь ирүүлсэн баримт, мэдээлэлд үндэслэн тандем нисгэгчийн үнэмлэх олгоно.

5.1.2 Ирүүлсэн баримт, мэдээлэл нь шаардлага хангаагүй гэж үзсэн тохиолдолд, давтан сургалт, шалгалтын нислэг шаардаж болно.

5.1.3 Нисгэгчийн үнэмлэхийг хуурамчаар үйлдэх, дамжуулж хэрэглэхийг хориглоно, ийм үйлдэл гаргасан тохиолдолд хуулийн хариуцлага хүлээнэ.

5.1.4 Нисгэгчийн үнэмлэхийг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд харьяалсан клуб болон МХПН-д мэдэгдэж, шинэчлэн авах өргөдлөө МХПН-д ирүүлнэ.

5.1.5 Үнэмлэх олгох, шинэчлэн олгохтой холбоотой зардлыг өргөдөл гаргагч төлнө.

5.2 **Тандем нисэгчийн үнэмлэх цуцлах:**

МХПН-с тандем нислэгийн үйл ажиллагаа эрхэлж буй зөвшөөрөлтэй нисгэгч нь олон нийт, спортыг эрсдэлд оруулсан, дүрэм, журам зөрчсөн гэж үзвэл тандем нислэгийн үйл ажиллагааны зөвшөөрөл болох үнэмлэхийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх, цуцлах эрхтэй.

5.2.1 МХПН-ны удирдах зөвлөлөөс түдгэлзүүлэх хугацаа болон цуцлах шийдвэрийг гаргаж, албан бичгээр үнэмлэх эзэмшигч нисгэгчид мэдэгдэнэ.

5.2.2 МХПН-с мэдэгдсэн мэдэгдлийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд үндэслэн түдгэлзсэн, цуцлагдсан үнэмлэх сэргээх албан хүсэлт нисгэгч гаргах бөгөөд МХПН-ны удирдах зөвлөл албан хүсэлтийг шийдвэрлэнэ.

ЗУРГАА. ДАЛАВЧ, НИСЛЭГИЙН ХЭРЭГСЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

6.1 **Далавч, нислэгийн аюулгүйн хэрэгсэл, төхөөрөмж, материалд тавигдах шаардлага:**

Тандем нислэгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа клуб, хувь нисгэгч нь тухайн үнэмлэхийн хүрээнд үйл ажиллагаанд ашиглах тандем шүхрийн иж бүрдэлд хийх техник үйлчилгээг холбооноос олгосон хүчинтэй шүхрийн техникчийн үзлэгээр баталгаажуулах үүрэгтэй.

6.1.1 Гэрчилгээжсэн далавчтай байх /DHV/

6.1.2 Зориулалтын тандем нисгэгчийн суудал, зорчигчийн суудалтай байх

6.1.3 180кг -с дээш даацтай аврах шүхэртэй байх

6.1.4 Аюулгүйн шаардлага хангасан /EN966, EN967/ хамгаалалтын дуулага, өвдгөвч, тохойвч

6.1.5 Нислэгийн үйл ажиллагаанд агаарын хурдыг үнэн зөв хэмжих стандартыг хангасан хэрэгслээр /варио/ тоноглосон байна.

6.2 **Тандем далавчны дугаарлалт**

Тандем нислэгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа клуб, хувь гишүүний нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж буй далавч нь газраас 100 м-ийн зайнаас уншигдахуйц дугаар, таних тэмдэглэгээгээр танигддаг байна. Далавчны дугаар, таних тэмдэглэгээг МХПН-с гаргасан стандартын дагуу далавч дээр буулгасан, дугаар, тэмдэгийг тандем нислэг үйлдэх бүрт нислэгийн бүртгэлийн хуудсанд давхар бүртгэдэг байна.

Хавсралт №1

ПАРАГЛАЙДЕРИЙН НИСЛЭГИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

НЭГ. ЗОРИЛГО

Нислэгийн өмнөх бэлтгэл болон нислэгийн үед нисгэгчийн аюулгүй байдлыг хангахад энэхүү аюулгүй ажиллагааны зааварчилгын зорилго оршино.

Параглайдингийн бүх төрлийн үйл ажиллагаа (сургалт, тандем нислэг, чөлөөт нислэг, тэмцээн уралдаан, чирэх төхөөрөмжтэй гараа болон бусад) нь оролцогч этгээдээ аюул эрсдэлд учруулж болзошгүй байдаг. Зарим нь уг спортын мөн чанартай холбоотой байх бөгөөд зарим нь хувь хүний алдаа, анхаарал болгоомжгүй, тоомжиргүй байдлаас үүсдэг. Ийм аюул эрсдэл учирсан тохиолдолд ноцтой гэмтэж бэртэх, хөдөлгөөн-тулгуур эрхтний бэрхшээлтэй болох, амь нас эрсдэх нөхцөл үүсэх, өмч хөрөнгийн эвдрэл гэмтэл, хохирол тохиолдож болно.

Учирч болох аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, түүнийг зайлуулах, багасгах, аль болох хохирол багатай даван туулах нь нисгэгч аюулгүй ажиллагааны дүрэм журмыг нягт нямбай дагаж мөрдсөнөөс ихээхэн шалтгаална.

Параглайдерийн нислэгийн аюулгүй байдал нь цаг агаарын нөхцөл байдал, хүчин зүйлээс их шалтгаалдаг учраас нисгэгч бүр аэродинамик, аэрологи, цаг агаар судлалын үндсэн мэдлэг болон хүчин төгөлдөр үйлчилж буй хууль журмуудын талаарх онолын мэдлэгээ байнга дээшлүүлэх шаардлагатай.

ХОЁР. НЭР ТОМЬЁО

Зааварчилгад дурдсан нэр томьёог дараахь утгаар ойлгоно. Үүнд:

“Далавч”- агаар нэвтрүүлдэггүй түсгай материалаар хийгдсэн бөгөөд агаараар дүүрсэн үедээ хөөрөх, агаарын урсгалд залуурдан нисэх боломжтой хэт хөнгөн нисэх төхөөрөмжийн гол бүрэлдэхүүн хэсэг

“Аврах шүхэр”- эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд нисгэгч болон зорчигчийг аюулгүй газардуулах зориулалттай шүхэр

“Суудал”- нислэгийн үед нисгэгч болон зорчигчийг суулган тээвэрлэх зориулалттай, түсгай оломт бэхэлгээгээр нисгэгчийн бие болон далавчтай холбогддог зориулалтын суудал. Харнесс гэж бас хэлдэг.

“Карбин”- далавчийг удирдах жолооны багц болон суудалтай холбох түгжээ

“Строп”- далавчны их биеийг карбинтай холбож буй түсгай материалаар бүтээгдсэн утас

“Хамгаалалтын дуулга”- нисгэгч болон зорчигчийн толгойг хамгаалах зориулалттай, стандартын дагуу хийгдсэн малгай

“Далавчны ангилал”- олон улсад далавчийг зориулалтаас нь шалтгаалан ангилсан байдаг бөгөөд үүнийг далавчны ангилал гэнэ.

“Далавчны хэмжээ”- далавч нь тээвэрлэх дээд болон доод жингийн хязгаартай байдаг бөгөөд нисгэгчийн жин болон зорчигтой үед нийт жинг тооцоолон далавчны хэмжээг сонгоно.

“Радио холбоо”- нислэг болон бэлтгэл ажлын үед баг, тамирчид болон зааварлагч хоорондоо холбоо барих хэрэгсэл

“Соло нислэг”- нисгэгч дангаараа нислэг үйлдэж байгаа тохиолдлыг соло буюу ганцаарчилсан нислэг гэнэ.

"Тандем нислэг"- нисгэгч зорчигчтой нислэг үйлдэж байгаа тохиолдлыг тандем буюу хосоороо нисэх нислэг гэнэ.

"Колдун"- гарааны болон газардах талбайд байрлуулсан конус хэлбэртэй, салхины чиг заах зориулалттай хэрэгсэл

ГУРАВ. ПАРАГЛАЙДЕРИЙН НИСГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1 **Эрүүл мэндийн дараахь заалттай тохиолдолд нислэг үйлдэхийг хориглоно**

- 3.1.1 Зүрх судасны өвчин
- 3.1.2 Амьсгалын замын хурц болон архаг өвчин
- 3.1.3 Тулгуур эрхтний гэмтэл, өвчлөл (ясны хугарал, гэмтэл, хагалгааны дараахь үе, булчингийн таталт)
- 3.1.4 Сэтгэц, мэдрэлийн өөрчлөлт (амархан ухаан алддаг, хөдөлгөөний эвсэл алдагдсан, уналт таталт өгдөг, шизофрени, сэтгэцийн гүн хямрал)
- 3.1.5 Жирэмсэн эмэгтэй
- 3.1.6 Гормоны өөрчлөлт

3.2 **Бусад тохиолдол:**

- 3.2.1 Согтууруулах болон мансууруулах бодис хэрэглэсэн, нөлөөнд автсан
- 3.2.2 Халуунтай, бие болон сэтгэл санааны байдал тавгүй үед
- 3.2.3 Төв мэдрэлийн системд дарангуйлах нөлөө үзүүлж нойрмог болгон, хариу үйлдлийг удаашруулдаг төрлийн эм бэлдмэл хэрэглэсний дараа
- 3.2.4 Нислэг хийхийн өмнө хангалттай унтаж амарсан, илчлэг тэжээлтэй хоол хүнс хэрэглэсэн байх шаардлагатай.

3.3 **Нислэгт шууд хамааралгүй ч биедээ заавал авч явах зүйлс:**

- 3.3.1 Цэнэгтэй утас, радио холбооны хэрэгсэл
- 3.3.2 Бичиг баримт (нисгэгчийн үнэмлэх, даатгалын бичиг)
- 3.3.3 Зориулалтын хутга
- 3.3.4 Ойр орчмын бүсэд такси, унаа дуудах утас, нийтийн тээврийн маршрут
- 3.3.5 Бүс нутгийн газрын зураг, компас
- 3.3.6 Бэлэн мөнгө

ДӨРӨВ. ДАЛАВЧ, ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

4.1 **Далавч:**

- 4.1.1 Зөвхөн EN гэрчилгээтэй далавчаар нисэхийг зөвшөөрнө. Зөвхөн өөрийн жин болон ур чадварт тохирсон хэмжээ ба ангилалын далавчаар нислэг үйлдэнэ.
- 4.1.2 Далавч бүр өөрийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ, нисэх зөвшөөрөл, үйлдвэрлэгчээс тогтоосон хязгаарлалтын хүрээнд ниснэ.
- 4.1.3 Далавчыг өөрийнх нь гэрчилгээний стандартаас өөр болгохуйц байдлаар өөрчлөхийг хориглоно. Зайлшгүй шаардлагатай засвар хийх болсон тохиолдолд солих эд анги нь анхны техникийн үзүүлэлттэй яг тохирч байх ёстой.

4.2 **Бүсад техник хэрэгсэл:**

4.2.1 **Суудал:** Бүх нисгэгчид 2022 он болон түүнээс хойшхи LTF09, EN1651 стандартын дагуу шалгаж, тохируулга хийгдсэн, нурууны хамгаалалт бүхий суудалтай ниснэ.

4.2.2 **Хамгаалалтын дуулга:** Бүх нисгэгчид нислэгийн үеэр EN966 (HPG), EN1077-A ба –B (Цасны спорт), ASTM 2040 (Цасны спорт) эсвэл Snell RS-98 стандартын гэрчилгээтэй дуулга өмсөнө.

4.2.3 **Аврах шүхэр**: Нисгэгчид ашиглах боломжтой аврах (ослын, нөөц гэж бас хэлдэг) шүхэртэй байх ёстой. Нисгэгчид аврах шүхрийн зөвшөөрөгдсөн жингийн дээд хэмжээн дотор байх ёстой.

4.2.4 Аврах шүхрийг 6 сар тутамд шалгах, шинээр эвхэх, шаардлагатай бол солих хэрэгтэй.

4.3 **Далавч хэрэгслээ хадгалах, тээвэрлэх, арчлах, хамгаалах:**

4.3.1 Далавч дээр суух болон хүнд зүйл дээр нь тавихыг хориглоно.

4.3.2 Далавчийг буулгаж ачих үед шидэх, унагаахыг хориглоно.

4.3.3 Далавч хэрэгслийг бороо, цас, нарны шууд тусгалаас хол байлгана.

4.3.4 Тос болон химийн бодистой хамт тээвэрлэхийг хориглоно.

4.3.5 Гараан дээр болон газардсаны дараа шавар шавхай, бохирдлоос хамгаална.

4.3.6 Газардсаны дараа зөв эвхэж хураана.

4.3.7 Чийг авсан, норсон тохиолдолд хатаасны дараа эвхэнэ.

4.3.8 Удаан хугацаанд нислэг үйлдэхгүй тохиолдолд хадгалалтын журмаар эвхэж хуурай, нарны шууд тусгалгүй газар хадгална.

4.3.9 Өөрийн болон өөр нисгэгчийн далавч дэлгээтэй байгаа үед далавч болон строп дээгүүр давж алхах, гишгэхийг хориглоно.

4.3.10 Далавч болон аврах шүхэр, суудал, карбин, строп зэргийн бүрэн бүтэн байдлыг тогтсон цаг хугацаанд багш, дасгалжуулагчаар үзлэг хийлгэж, шаардлагатай засвар үйлчилгээг цаг тухайд нь хийнэ.

4.3.11 Далавчинд өөрийн дураар засвар үйлчилгээ хийхийг хориглоно.

ТАВ. ТАНДЕМ НИСЛЭГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

5.1 **Нислэгийн өмнө зорчигчтой хийх аюулгүй байдлын үзлэг:** (минимум 10-15 минут)

7.1.1 Зорчигчийн бие бялдрын болон сэтгэл санааны байдалд үнэлгээ өгөх, ингэхдээ:

a. Аюулгүй хөөрөх, газардахад шаардлагатай даалгаврыг гүйцэтгэж чадах уу?

b. Болох гэж буй нислэг, түүнд багийн идэвхтэй гишүүний хувиар оролцох гэж байгаагаа ухамсарлаж, заавар зөвлөгөөг дагахад бэлэн байна уу?

7.1.2 Нислэгийн өмнөх үзлэгийн зорилго нь танин мэдэхүйн чанартай гэдгийг зорчигчид ойлгуулж, аэродинамикийн хамгийн энгийн зарчмууд болон нисэх төхөөрөмжийн дизайн, үйл ажиллагааг товч тайлбарлах

7.1.3 Аврах хэрэгслийн талаар товч ойлголт өгөх

7.1.4 Суудлыг яаж өмсөх, суудалдаа яаж суухыг тайлбарлах

7.1.5 Далавчны гол бүрэлдэхүүн хэсгүүд болоод зорчигч, нисгэгч хоёр далавчтай хэрхэн холбогдож бэхлэгдэхийг тайлбарлах

7.1.6 Хөөрөх, газардах зарчмыг тайлбарлах

7.1.7 Байж болох эрсдэл, түүний учир шалтгаан, түүнийг багасгах арга замуудыг ил тодорхой хэлж, зорчигч өөрийн зүгээс эрсдлийн үнэлгээг хийж, гүйцэтгэх үүргээ ойлгосон байх

7.1.8 "Хариуцлагаас чөлөөлөх мэдэгдэл"-ийг анхааралтай уншиж, гарын үсэг зурахад хангалттай хугацааг зорчигчид олгох

7.1.9 Нислэгийн өмнөх ердийн бэлтгэлийг бүрэн хийж дуусгах:

а. Зорчигч, нисгэгч хоёулаа хамгаалалтын дуулгаа өмсөж, эрүүний бэхэлгээг тохируулна.

б. Далавч, суудал ямар нэг гэмтэл согогүй бөгөөд аврах шүхрийн бариул, тэвх зөв байрлалд байгаа эсэхийг шалгана.

в. Нисгэгч, зорчигч хоёулаа суудлаа өмсөж, оломны түгжээсүүдийг түгжин, далавчтай холбоно.

г. Карбин болон холбогч найдвартай түгжигдсэн эсэхийг шалгана.

7.2 Хөөрөхийн өмнө шалгах хуудас (pre-launch checklist)

Шалгах хуудас (checklist) нь нисгэгчийн суудлын цүнх, халаасанд бэлэн байх бөгөөд зорчигчийн анхаарлыг түүнд хандуулж, дахин нэг удаа шалгана.

7.3 Бусад анхаарах зүйлс:

7.3.1 Тандем далавч болон бусад хэрэгсэлд үйлдвэрлэгчийн шаардлагын зааврын дагуу тогтмол үзлэг шалгалт, шаардлагатай бол засвар үйлчилгээг цаг алдалгүй хийж, шаардлага дээд зэргээр хангасан нөхцөлд хадгалах

7.3.2 Олон зорчигчтой захиалгат нислэг, урамшууллын хөтөлбөртэй нислэгийн үеэр цаг хугацаа давчуу байх нөхцөл байдал үүссэн ч тандем нисгэгч нислэгийн өмнөх бэлтгэлийг стандартын дагуу бүрэн хийж гүйцэтгэх ёстой.

7.3.3 Тандем нисгэгч өөрийн бие бялдарын ядралт, сэтгэл санааны байдалд бодитой үнэлэлт дүгнэлт өгч, шаардлагатай бол амрах, нислэгээ зогсоох шийдвэр гаргаж чадах ёстой.

7.3.4 Камер зэрэг бусад төхөөрөмж ашиглаж болно, гэхдээ аврах хэрэгсэлд саад болохооргүй байдлаар байрлуулж хэрэглэнэ.